

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ренчингийн Агваанчандав	Дугаар	L249
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Номгон сумын Дөхөм баг
Төрсөн газар	Номгон сум	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Эхэн загийн хийд	Сүм хийдийн дугаар	ӨГНМ 028
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 11	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Номгон сумын Эхэн загийн хийд

Гантулга: За та өөрийгөө танилцуулна уу?

Агваанчандав: За би бол тэндээс гарснаа муухан мэдэхээс илүү мэдэхгүй. Тэгээд одоо нэг хэдэн малаа маллаад л суугаад байхаас...

Гантулга: Анх та ширээнд яаж залагдсан тухайгаа ярихгүй юу?

Агваанчандав: Тэрийг би мэдэхгүй юм. Хэзээ яаж ч яваад орчихсон юм.

Гантулга: Тэр хуралд шавилан сууж байсан тухайгаа?

Агваанчандав: Нэг л жаалын эхэндээ хуралд суулгуулж байгаад л, хуралд сүж байгаад л гардаг байсан. Тэгээд л нэг хүүхэдтэй л орж ирдэг, хүүхэдтэй л гардаг байсан.

Гантулга: Яг хэдэн настай байснаа санаж байна уу, та?

Агваанчандав: Арван хоёртой л гараад явчихсан юм, гарахад.

Гантулга: Аан за, ширээнд суухдаа?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Агваанчандав: Ширээнд суухдаа тэрийг мэдэхгүй юм.

Гантулга: Та тэр Эхэн загийн хийдийн тухай , тэр хурал номынх нь талаар товч мэдээлэл өгнө үү? Хэдэн ламтай байсан ...?

Агваанчандав: За барагцаагаар нэг хоёр зуу орчим лам нар байсан болов уу гэж санах юм, чухам яг мэдэх юм бол байхгүй.Тэрэн дээр болвол гавжийн дамжаа хурдаг, Чойр хурдаг тийм л байсан. Гүнриг дацан , Дүйнхор дацан бүгд хурдаг байсан.Тэгээд чухам цааш нь юу хурдаг байсныг нь мэдэхгүй юм.

Гантулга: Хэдэн жастай байсан бол, та түрүүнд нэг нэрлэж байсан даа?

Агваанчандав: За таван жас л лав байсан .

Гантулга: Ямар ямар жа байсан ?

Агваанчандав: Дүйнхор жас, Гүнрэг жас, Цогчин жас, Дончид жас...нэг нь юу гэж байлаа даа, одоо. Дор дороо дугантай байсан, баруун талаараа гурав дөрвөн дугантай байсан, зүүн хийд нь ганцхан дүйнхор дуган байсан.

Гантулга: Энэ хийд нь одоо ойролцоо ямар ямар хийдүүдтэй холбоо харилцаатай байсан , та түрүүнд нөгөө гол хийд нь байсан гээд ярьсан ш дээ?

Агваанчандав: Аа тэр улаан гариг, тэр Тутган энэ хоёр хийдийг лав захирдаг байсан байх. Аа тэр хойд Сангийн далай бол хамаа байхгүй.

Гантулга: Энэ хийдийн одоо тэр ширээнд залагдаж байсан гэсэн ш дээ, тэр урд дүрийнх нь одоо ямар ямар лам нар байсан бол?

Агваанчандав: Тэрнийг мэдэхгүй юм.

Гантулга: Ер нь одоо тэр гэсгүй, унзад, цорж гээд ямар ямар лам нар байсан бол?

Агваанчандав: Жавзан унзад гэж байсан, Халтмаа унзад гэж байсан. Тэр зүүн хийдийн гүнгэриг лам болохлээр Чойжамц гэж байсан. Баруун хийдийн нь болохлээр манай багш Цогжид лам гэж байсан юм.Галсанчойжив гэдэг хүн чинь цорж нь байсан юм.

Гантулга: Тэнд одоо ямар ямар хурал хурж байсан бол?

Агваанчандав: Тэрийг чинь сайн мэдэхгүй юм . Хэдэн дацангууд л хурж байсан байх. Арван Догшид гэж хурж байсан ...

Гантулга: Гол сахиус нь ямар сахиус байсан юм бол?

Агваанчандав: Гомбо.

Гантулга: Гомбо сахиустай байсан уу?

Агваанчандав: Тийм. Маань гэж хурдаг байсан.

Гантулга: Цагаан сараар...?

Агваанчандав: Цагаан сараар чинь цам яам залж шинэлдэг байсан.

Гантулга: Аан за , битүүний орой?

Агваанчандав: Битүүний шөнө.

Гантулга: Өөр одоо ямар ямар хурлууд хурдаг байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Агваанчандав: Тэрнийг чинь би заримыг нь мэдэхгүй юмаа, цугийг нь . Маань л гэж лав хурдаг байсан.

Гантулга: Маанийг одоо хэдий цаг үеэр, хугацаа нь одоо хэдийд хурдаг байсан?

Агваанчандав: Зун л хурдаг байсан, маань гэж.Тэр Арван догшид нь голцуу өвөл хурдаг байсан.

Гантулга: Одоо цам гарах юм уу, сор залах ч юм уу...?

Агваанчандав: Цагаан сараар л байдаг байсан. Майдар эргээд...

Гантулга: Аан майдар эргээд.Хайлан хийдэг байсан уу?

Агваанчандав: Хийдэг байсан. Хайлан гэж хурдаг байсан. Би тэрэнд нь хүрж байгаагүй ээ.

Гантулга: Гэлэн , гэцэл лам нар одоо олон байсан байх даа?

Агваанчандав: Олон байсан. Бараг нь л гэлэн, гэцлүүд байсан.

Гантулга: Аль үрсгал чиглэлийн хурал байсан бол? Гэлгүй одоо шарын шашных байсан уу, улааны талын хурал байсан уу?

Агваанчандав: Шарын шашных.

Гантулга: Тэр гавжийн дамжаа барьдаг байсан гээд та түрүүн хэлж байсан , тэр талаараа тодруулахгүй юу?

Агваанчандав: Гавжийн дамжааг чинь хоёр хүн голд нь суугаад бусад лам нар нь зогсдог байсан . Чухам яаж...

Гантулга: Аан тахилаа хийдэг байсан уу?

Агваанчандав: Тэгдэг байсан.

Гантулга: Олон лам нар тахилаа хийдэг байсан уу?

Агваанчандав: Аа ер нь бүгд, цугаарангийн нь .

Гантулга: Зиндаа, зиндаа хэдэн зиндаа байсан юм бол?

Агваанчандав: Тэрийг нь мэдэхгүй юм.

Гантулга: Олон лам нар тахил хаях үү?

Агваанчандав: Тэгнэ.

Гантулга: Зиндаагаараа босоод л ...

Агваанчандав: Тийм.

Гантулга: Ном хаялцах уу?

Агваанчандав: Тийм. Тэгсээр байгаад хоёр хүн болдог байсан.

Гантулга: Тэгэхээр одоо гавжийн дамжаа байсан юм чинь, домын дамжаа , нянх дом энэ тэр гэж хурдаг байсан уу?

Агваанчандав: Нянх дом гэж хурдаг байсан.

Гантулга: Аа за тэр хэдий үед яаж хурдаг байсан бэ?

Агваанчандав: Зун л хурдаг юм байсан.

Гантулга: Тэр талаас нь та тодруулвал, таны багад одоо...?

Агваанчандав: Миний багад одоо, би хүрж байгаагүй болохоор сайн мэдэхгүй юм. Зүгээр нянх дом хүрж байгаа гээд айраг л их төхөрдөг байсан, тэгэхээр зун л хурдаг байж таарна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ Төвдөөс юмуу, одоо хүрэнээс том алдартай лам нар ирж ном айлддаг байсан уу?

Агваанчандав: Үгүй, мэдэхгүй юм.Төвдөөс тэр яадаг байсан юм , мэдэхгүй юм.

Гантулга: Өөр одоо сүм хийдээс лам нар ирж, хурал ном хурж , дамжаанд суудаг энэ тэр юм байсан уу?

Агваанчандав: Өөр хийдээс үү? Лам нар ирж хурдаг байсан. Дуудаад л ирж байсан.

Гантулга: Төвдөөс юм үү, Өвөрмонголоос лам нар ирж...?

Агваанчандав: Үгүй, тэрнийг мэдэхгүй юм.

Гантулга: Эргэл , мөргөлчид одоо нутгийн сүсэгтэн олнууд хэр ирдэг байсан бэ?

Агваанчандав: Одоо тэр нэг майдар энэ тэр эргэх үеэр л ирдэг байсан даа. Бусад талаар мэдэхгүй юм.

Гантулга: Та одоо ээж аавтайгаа урагшаа гарж байсан гэсэн ш дээ, багш аваад?

Агваанчандав: Тийм.

Гантулга: Тэр талаараа нэг тодруулаач? Таныг хэдэн настай байхад явсан?

Агваанчандав: Арван хоёртой л байхад аваад явчихсан юм. Тэгээд Өвөрмонголд очоод багш ч ном заахаа байсан, би ч ээж аавтайгаа л хэдэн малтайгаа л байдаг байсан.

Гантулга: Тэгээд хэдэн онд орж ирсэн билээ?

Агваанчандав: Дөчин найман онд орж ирсэн.

Гантулга: Тэгээд...?

Агваанчандав: Тэгээд тэнд байхад Гүндэнжавд нэг мөргөсөн, зүүнтээ явж Ванчин Богдод Сөрил вангийн оройд мөргөсөн.

Гантулга: Аан за Ванчин Богдод мөргөсөн юм байна , тийм ээ?

Агваанчандав: Тэгсэн. Тэрнээс илүү яваагүй. Тэгэхэд манай аав, аав маань явчихдагаас хойш.

Гантулга: Тэгээд л мөргөчихөөд л буцаад ирсэн үү?

Агваанчандав: Тэгээд л буцаад энэ Рашаан нутагтаа ирсэн.

Гантулга: Тэгээд тэр Рашаан нутагт байхаар энэ Рашаантын хийдээс лам нар хурал хурж байсан гэсэн ш дээ. Тэр талаар та тодруулаач?

Агваанчандав: Тэрэн дээр одоо тэр ямар хурал хурдаг байсан юм, наадам хийж байхад очиж байсан.Тэрнээс очоогүй.

Гантулга: Хэр олон лам нар байсан бэ?

Агваанчандав: Үгүй ээ тэр арваадхан улс л байсан байх.

Гантулга: Тэгээд л хурлаа хураад л ..?

Агваанчандав: Хурлаа хураад л арваад хүн сууж байдаг юм байсан.

Гантулга: Тэрэн дээр таньдаг лам нар байсан уу?

Агваанчандав: Аа эндээс очсон ганц нэг лам нар үзэгддэг л байсан.

Гантулга: Нэрлэвэл?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Агваанчандав: Нэрлэвэл, Жамцдойм гэж байсан, Жамц унзад гэж бас байсан.Лувсанжав унзад гэж нэг байсан.Тэгээд л Равжаа унзад гэж энд байсан хүн, тэнд оччихсон байж л байсан.

Гантулга: Аа энэ Эхэн загийн хурал дээр байсан?

Агваанчандав: Тийм. Эхэн заг дээр байсан лам нар тэнд үзэгдэж байсан.Тэгээд тэр өдөр чинь яасан бүү мэд...

Гантулга: Тэгээд л хурлаа залгуулаад л байсан?

Агваанчандав: Дор дороо нэг хэд хэдэн малтай айлууд л байсан.Хурал ном гэж байхгүй юм чинь.

Гантулга: Таныг одоо явахад энэ хурал ном яг хэвээрээ л байсан уу? Дуган сүм чинь...?

Агваанчандав: Огт хэвээрээ байсан.

Гантулга: Тэр талаараа нэг тодруулаач?

Агваанчандав: Тэр дуган нь огт хэвээрээ, хурлаа хурдаг хэвээрээ л байсан. Тэр дуган хуралдаа очно гэж хэлээд л манай багш чинь тэгээд л явсан, тэгээд дуган хуралдаа ч очсон юм уу үгүй юмуу мэдэхгүй. Манай Рашаантын тэр жижиг гэр бололтой ,нэг жоохон жижиг гэр ачаад л тэгээд л тэр толгойтыг даваад л явсан шиг санагдана. Тэгээд л саранд ч гэсэн, яваад л байсан хүн дээ, саранд үүрэглээд...Мэдэхгүй юм.

Гантулга: Хэдэн дугантай байсан, тэр хийд дээр өөр одоо суварга , сүм хийд одоо ямар ямар суварга байсан, тэр талаар бас яриач?

Агваанчандав: Гүнриг сүм, Дүйнхор сүм, Цогчин сүм, тэр Донжид жасар гэж сүм байсан юм , би мэдэхгүй юм.

Гантулга: Суварга?

Агваанчандав : Хөндий суварга гэж нэг өмнө нь байсан. Хойно нь нэг суварга байсан. Лүндэн овоо гэж ямар юм байлаа даа, бас мэдэхгүй мартчихаж. Нэг цагаан юм л харагддаг байсан.

Гантулга: Лүндэн овоо?

Агваанчандав: Тийм.

Гантулга: Тэр нь ойролцоо байсан юм уу?

Агваанчандав: Энэ гороогоо тойроод гүвээний доор байсан юм.Хөндий суварга нь тэр Цөмөө улын тэнд байсан юм.Цөмөөн тойруулаад цагаан хашаатай.Тийшээ чинь тэгээд гардаггүй.

Гантулга: Тэр тахидаг байсан уул ус, ямар уул ус тахидаг байсан тэр хавьдаа?

Агваанчандав: Баруун хойшоо Хараатыг тахидаг байсан. Урагшаа Булганыг тахидаг байсан. Цагаан даль гэж нэг тахидаг байсан.Өшөө чухам сайн мэдэхгүй юм.

Гантулга: Уул усаа тахихдаа наадам хийдэг байсан уу, зөвхөн лам нар нь очоод тахидаг байсан уу?

Агваанчандав: Хоёр хүн, гурван лам нар л очдог. Тэгээд л нутгийн ардууд л цуглачихдаг.

Гантулга: Хэдий үед тахидаг байсан бэ?

Агваанчандав: Голдуу зуны эхэн сард л ...Тэмээ унаад л явж байсан шиг санагдаж байна. Тэгэхээр зуны эхэн сард л ...

Гантулга: Энэ хийд дээр ер нь цам гардаг байсан уу?

Агваанчандав: Цам гардаг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Цам гарахад нь та очиж байсан биз дээ?

Агваанчандав: Цам гарахад нь нэг хэдэн хүн юм өмсчихсөн харагддаг л байсан. Сайн мэдэхгүй юм./инээв/

Гантулга: Сүүлд та нэг урдаас орж ирээд ээж аавтайгаа энд амьдардаг байхаасаа өмнө Улаанбаатар орсон гэж нэг ярьж байсан ш дээ, тэр талаараа яриач?

Агваанчандав: Хотод очоод л нэг байшинд цоожтой байж байгаад л наяд хоночихоод л буцаад ирсэн дээ.

Гантулга: Тэр одоо эндээс яагаад авч явсан талаараа?

Агваанчандав: Эндээс зүгээр энэ хийд дээрээс л ...

Гантулга: Ямар хүн авч явсан , анх орж ирэхэд чинь яасан тэр талаараа?

Агваанчандав: Анх орж ирэхэд нэг суурингий төв газар сууж байсан чинь хоёр буутай цэрэг бариад л авсан.Тэгээд манайх чинь одоо Цагаан толгойн хажууд бүүчихсан байсан. Тэнд нэг өглөө цэрэг давхиад л ирсэн. Надыг ир гэж байна аа гээд л тэгсэн, ирээд л очсон, машиндаа суу гэж байна, суусан. Тэгээд хүнгүй газар доош харуулж суулгачихаад дахаар бүтээчихээд хөдөлж болохгүй тэгээд л хүнгүй газар суугаад л явсан.Тэгээд дамжсаар яваад Улаанбаатарт л очсон.

Гантулга: Тэгээд?

Агваанчандав: Тэгээд харанхуй шөнө нэг байшинд аваачихаад л гадаа үүдээс цоожилчихсон. Тэгээд л шөнө нэг хүн гарч ирж нэг газар аваачиж тэгж хоргоож байгаад л тэгээд л яагаад гарсан даа.Өмнө юу хийж байсан , тийм л юм асуугаад байсан. Тэгээд л аваад явсан, сураггүй. Тэгээд л манай багшийг асуугаад л байсан, би мэддэггүй гээд л.Тэгж байгаад л нэг наяд хоночихоод нааш нь машитай давхиад л ирсэн.Тэгээд л аймаг дээр ирж нэг хэд хоночихоод л одоо явна аа гээд л тэгсэн, тэгээд л гэр лүүгээ явсан.

Гантулга: Тэгэхэд аав ээж чинь ирчихсэн, энд байсан биз дээ?

Агваанчандав: Ирчихсэн. Энэ аймгийн голд байсан.Тэгээд л аав ээжтэйгээ мал маллаад л тэр ухаа хонгорт таван жил болсон. Тэгээд л та одоо орон нутагтаа сууж болно оо гээд л тэгсэн ,тэгээд л одоо ингээд л сууж байна.

Гантулга: Тэгээд л одоо хүртэл эндээ?

Агваанчандав: Тийм. Хашаагаар салгуулчихсан юм. Ганцхан гүвээний хоёр талд л болохоос.

Гантулга: Аа нэг л хийд юм байна, тиймээ?

Агваанчандав: Нэг л хийд.

Гантулга: Баруун сүм...

Агваанчандав: Зүүн сүм. Өнөө гүвээний хоёр талд болохлээр тэгж нэрлэсэн байлгүй дээ. Түүнээс биш нэг л юм чинь. Голуураа хуваачихсанаас биш ганц юм чинь.Өөр юм мэдэхгүй юм.Гавжийн дамжаанаас хоёрхон хүн гавж болж байсан. Түүнээс түрүү...нэртэй гавж гэж дуулаагүй байх аа, мэдэхгүй юм. Манай багш, Шарав гэлэн гэж хоёр хүн л гавж болж байгааг би мэдэх юм.

Гантулга: За, дамжаа барьж?

Агваанчандав: Тэрнээс түрүү нь гавж байсан хүнийг нь би мэдэхгүй юм.

Гантулга: За баярлалаа ,ярилцлага өгсөнд.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Агваанчандав: За баяртай.Тэр ...хийдийн эзэн лам нь хажуудаа юм чинь тэр хүн л мэддэг байх даа.Тэр Ламиран гэдэг хүн.

Гантулга: Тэр хүн хэдийд залагдаж ирсэн гэнэ ээ , тэр талаар нэг товчхон?

Агваанчандав: Тэр хүн дөнгөж залагдаад ном заалгах болоогүй энэ хувьсгал ялчихсан юм. Дөнгөж шинээр залагдаад , ном заалгах зав болоогүй...

Гантулга: Сангийн далай хийд байсан гэсэн, тийм ээ?

Агваанчандав: Тийм.

Гантулга: За.

Агваанчандав: Тэр жинхэнэ тийм хойноо тусгай байсан юм гэсэн. Тэр хүрээ дэгтэй, тусгай юм гэнэ лээ.

Гантулга: Энэ Эхэн загийн хийд бол аль газрын дэгтэй байсан?

Агваанчандав: Энэ Гомон хааны дэгтэй байсан болов уу гэж л санах юм.

Яжий ганжай дугар най

Дугар шоосор гунгай жог

Цогжий жанлав гунжин лугсаа

Нараа сайдан живаа нандир шагсүү саг. Иймэрхүү л аятай уншдаг байсан юм.

Цогжий гунсай наваан жансан.

Даргаа дандий содном жалжий

Дажий дамбаа шажир дэгир гагир гагсүү .

Гантулга: Арван хоёр хүртлээ...?

Агваанчандав: Гавж , Чойдог хоёрыг бүтэн цээжлээд, тэгээд Дүйнхорт хурсан юм.Тэгээд одоо Дүйнхорт чинь юу гэдэг билээ бүү мэд.Тэр цорж лам бол шалгалт өгч байж орно.

Гантулга: Юу юугаар шалгалт өгөх үү?

Агваанчандав: Арван догшидоор бүгдийг нь шалгалт өгнө. Тэгээд гүнригтээ шалгалт өгч байж нэг алдаад, тэгээд аргагүйн эрхэнд...

Гантулга: Гучин хоёр магтаал?

Агваанчандав: Тэрнийг сайн мэдэхгүй...мартчихжээ.

Гантулга: Ерөөл?

Агваанчандав : Найман ерөөл мөрөөлийг чинь уншдаг л байсан. Одоо ч мартчиаж. Тэр дүгэр мүгэр , цагаан шүхэртийг чинь цээжээрээ уншдаг л байсан. Одоо юу гэж эхэлдгийг нь ч мэдэхгүй . Сайхан мартдаг юм байна аа.